

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Буянт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2026/143/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Баян-Өлгий аймаг

2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл

Утас:99422227 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 99932710 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Аудитор: Р.Содномдаржаа

Утас: 99101563 Цахим хаяг: Uujimaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт /Баталгаажсан хувийг оруулах/



БУЯНТ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ И.ХАЙРЫМ ТАНАА

2026.02.24 № 109.
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Буянт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Буянт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Буянт сумын ерөнхий боловсролын сургууль нь 2025 онд 3,228.7 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 3,050.5 сая төгрөг зарцуулж, 94.5 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

• 832605000061

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

Буянт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,228,709,800.00	3,050,530,528.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,228,709,800.00	3,050,530,528.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,147,137,800.00	2,979,933,178.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,120,341,300.00	2,094,831,828.90
210101	Үндсэн цалин	1,289,527,800.00	1,198,066,127.65
210102	Нэмэгдэл	799,063,700.00	818,818,445.73
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	31,749,800.00	77,947,255.52
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	279,110,500.00	262,050,300.00
210201	Тэтгэврийн даатгал	189,422,600.00	175,440,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	22,422,000.00	21,989,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,210,900.00	10,320,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	11,210,900.00	10,320,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	44,844,100.00	43,980,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	502,505,900.00	393,724,500.00
210301	Гэрэл, цахилгаан	36,886,900.00	21,056,651.00
210302	Түлш, халаалт	465,619,000.00	372,667,849.00
210303	Цэвэр, бохир ус		
2105	Нормативт зардал	114,080,800.00	99,413,250.00
210502	Хоол, хүнс	114,080,800.00	99,413,250.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	1,500,300.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	1,500,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,754,100.00	31,291,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,380,300.00	4,380,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	27,373,800.00	26,911,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	97,345,200.00	97,121,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	88,054,300.00	87,888,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,290,900.00	9,232,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	81,572,000.00	70,597,350.00

Буянт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	81,572,000.00	70,597,350.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,228,709,800.00	2,950,053,800.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,596,247,900.00	2,545,288,700.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,596,247,900.00	2,545,288,700.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	504,505,900.00	395,224,800.00
132001	Орон нутгийн төсвөөс	504,505,900.00	395,224,800.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	127,956,000.00	9,540,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,380,300.00	4,380,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,160,000.00	5,160,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	118,415,700.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		119,361,077.05
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		18,884,348.15
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	80.00	79.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	49.00	48.00
620003	Үйлчлэх ажилтан	30.00	30.00
620004	Гэрээт ажилтан		
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	446.00	446.00
630001	Төрийн өмчит ЕБС	446.00	446.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	80.0	79.0
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	49.00	48.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	1.00	1.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	30.00	30.00

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 76.6 сая төгрөгийн алдаа¹ илэрч, аудитын явцад 76.6 сая төгрөгийн алдааг залруулсан. *Залруулсан алдаа:*

1. Сургууль нь түлш халаалтын зардлын батлагдсан төсөв, гүйцэтгэлийн зөрүүгээр 92.9 сая төгрөгийн өглөг үүсгэж санхүүгийн тайланд тусгаж ирүүлсэн байна. Аудитаар халаалтын

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Буянт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

нийт талбайд батлагдсан үнэ тарифын дагуу 385.6 сая төгрөгийн халаалтын зардал төлөх тооцоотой ба халаалт нийлүүлэгч компанид төлсөн 369.2 сая төгрөгийг хасаж тооцоход 16.3 сая төгрөгийн өглөгтэй гарч байгаа бөгөөд санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, өглөгийн тодруулгад өглөгийг тус тус 76.6 сая төгрөгөөр залруулсан.

Энэ нь Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар санхүүгийн асуудалтай холбоотой зөрчилд² нэг зөвлөмж өгсөн.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Түлш халаалтын зардлын төсвийн зарцуулалт, тооцоотой холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Сургуулийн захирал 2025 оны 01 дүгээр сарын 01-ны өдөр “Акбейл” ХХК-тай дулааны эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ байгуулахдаа Эрчим хүчний зохицуулах хорооны хүчингүй болсон 2014 оны 189 дүгээр тогтоолыг үндэслэл болгосон, гэрээнд байгууллагын халаалт авах нийт талбайн хэмжээ, сар бүр төлөх төлбөрийн мөнгөн дүнг тодорхой тусгаж өгөөгүй байна.

Тус сургууль нь тайланд онд халаалтын зардлын төсвөөс 372.6 сая төгрөгийг дулаанаар хангагч “Акбейл” ХХК-нд төлсөн бөгөөд халаалтын зардлын батлагдсан төсөв 465.6 сая төгрөгийн зөрүүгээр 92.9 сая төгрөгийн өглөг үүсгэж санхүүгийн тайланд тусгасан байна.

Сургуулийн хичээлийн хуучин, шинэ байр, дотуур байр, спорт заал, гал тогооны байрны халаалтын нийт талбайд батлагдсан үнэ тарифын дагуу нийтдээ 385.6 сая төгрөгийн халаалтын зардал төлөх тооцоотой ба “Акбейл” ХХК-нд төлсөн 369.2 сая төгрөгийг хасаж тооцоход 16.3 сая төгрөгийн өглөгтэй гарч байгаа бөгөөд санхүүгийн тайланд 76.6 сая төгрөгийн өглөгийг илүү харуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 зүйлийн 15.2.1-д “байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Дулааны эрчим хүч худалдах, худалдан авах гэрээг Эрчим хүчний тухай хууль болон Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны 164 дүгээр тогтоолоор баталсан “Дүрэм шинэчлэн батлах тухай” дүрэмд нийцүүлэн шинэчлэн байгуулах, гэрээнд халаалт авах талбайн хэмжээ, төлбөрийн мөнгөн дүнг тодорхой тусгаж, халаалтын зардлын төсвийн зарцуулалтад тавих дотоодын хяналтыг сайжруулах;

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Буянт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өглөгийг илүү тусгаж тайлагнасан	1	76,604.8			1	76,604.8	1	76,604.8				
Дүн	1	76,604.8			1	76,604.8	1	76,604.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган

төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Халаалтын гэрээнд халаалтын талбай, төлөх мөнгөн дүнг тодорхой тусгах, хяналтыг сайжруулах	1						1					
Дүн	1						1					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								